



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 5/12

Ховд


Албан үүргийг түр орлон
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.3.2, 43.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга албан тушаалаас чөлөөлөгдсөн тул сул орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд даргын албан үүргийг тус газрын хэлтсийн дарга Баасандоржийн Төгөлдөрт 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хариуцуулж, түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
2. Б.Төгөлдөрт Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын дагуу албан үүрэг түр орлон гүйцэтгэсний цалин, урамшууллыг тооцон бодож, сар бүр олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ерөнхий нягтлан бодогч (Г.Эсбаатар)-д зөвшөөрсүгэй.
3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Б.Төгөлдөрт даалгасугай.
4. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Ч.Эрдэнэбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Э.БОЛОРМАА



8400001 0370
Zah B/12 Ba